



## БАЯНХОНГОР АЙМАГ ЖАРГАЛАНТ СУМ СОЁЛЫН ТӨВ



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН  
АЯЛАЛЫН МАРШРУТ



2013 он

## Янгирын баримал

Гяланхайн хадны цохионд  
Гайхалтай зохицсон баримал  
Гарын уртай хүмүүний  
Гавъяаг мөнхлөх бүтээл  
Галав юүлсэн ч үлдэх  
Урлан сийлсэн бичээс  
Хөндлөн булаг нэр нь  
Хаданд сийлж гангарсан  
Хайр хүндэтгэл хамтатган  
Халуун сэтгэлээр урласан юм.  
Тэнгэрийн тамгат нутгийнхаа  
Тэнхлүүн амьтны дүрээр  
Түмэн олныхоо сэтгэлийг  
Төлөөлж бас товойлгосон юм.



Жаргалант сумын төвөөс 20-оод км-т Хөндлөн булаг багийн нутаг Гяланхайн аманд 3-р багийн хаяг болох Янгирын баримлыг сум орон нутаг өөрийн хөрөнгөөр Баянхонгор аймгийн барималч Сосорбарам гуайгаар бүтээлгэсэн.

### Монголын нууц товчооноо мөнхөрсөн түүхт Заг Байдрагийн хүрэн бэлчир



**МЯНГАНЫ СУУТ ХҮН ЧИНГИС  
ХААНЫ ХӨШӨӨ  
(ХҮРЭН БЭЛЧИР)**



**ЧИНГИС ХААНЫ ХОНОГЛОСОН  
ГАЗАРТ БОСГОСОН ХӨШӨӨ  
(Загийн голын Цагаан эрэг)**

## БАЙДРАГИЙН ГОЛ



Халх Өөлдийн дайны үед ажээ. Одоогийн Байдрагийн голын сав нутагт их дайн болж олон хүний амь үрэгдэж голын ус улаанаар урсаж байсан гэдэг домог бий. Мөрөн болоход 1 горхи дутсан гэдэг. Байдрагийн гол 3 үерлэвэл зун болдог гэж нутгийн хөгшчүүл ярилцдаг. Энэхүү зурагт Байдрагийн гол маань үерлэж бүх салаа нь гүйсэн нь үнэхээр түүхийг илтгэх бөлгөө.

### **Байдрагийн голын домгон шүлэг /Яруу найрагч Д.Жавхлан/**


Урьдын урьд гэж  
Домог эхэлдэг үед гэнэлээ  
Ус мөрөн гол омогт дайны хөлд үйж  
Усаар урсдаг гол минь  
Омогт дажны хөлд үйж  
Усаар урсдаг гол  
Цусаар цалгин урсаж  
Бусармаг дайны утаан дунд ивэрч  
Булингартаж байсан нь үнэн юм гэнэлээ  
Хөнөөлт дайны ланчигийг гол хүртэл үүрч  
Хөвөөгөө хальсан цус л байсийм гэнэн лээ  
Ариухан гол минь ариухнаараа үлдэг гэж  
Айлууд бүхэн хөдлөж  
Сүртэй оволзох улаан голруу  
Сүү хийж үзсэн юм гэнэлээ  
Нил улаан өнгийг дарж чадалгүй  
Нэмэргүйээ Сүү ээдчихээд байсийм гэнэлээ  
Хүн бүхэн зөвлөлдөж  
Хөсөг бүхэн хөлхөлдөж  
Хөнөг хөнгөөр тараг  
Хөхүүр хөхүүрээр айраг



Цусаар урссан голруу  
Цутгаж эхлэсэн юм гэнэлээ  
Тавилангийн хазгайг тэгшилж  
Тамын үйлийг хааж  
Таргаар асгасан цагаан гол  
Тавин хоног овогзсийм гэнэлээ  
Уулан дээрээс хэн нэгэн харчихаад  
Уулга алдан “Баянтараг”-ийн гол гэсийм гэнэлээ  
Мөн л тэр дайны уршиг юм гэнэлээ  
Мөрөн болох хувь ганц голоор дутсийм гэнэлээ  
Айл бүхнээр орж  
Амьтан бүхнээс сураглавал  
Ариухан энэ голоо Мөрөн гэж  
Ам бардам хэлдгийм байна лээ.

### **Нутгийн хүүгийн амин чулуу, нутгийн түмний шүтээн чулуу**

Нутгийн хүү яруу найрагч Бямбажавын Ганбаатар 2008 онд Хүрэн бухтын овоон өөрийн зохиолын дээжээ сийлсэн боржин чулууг өдрийн сайнд залж авчирч байршуулсан.



## Жаргалант сумын босго,үүд хаалга

Хүрэн бухтын “Насан буян дэлгэрэх овоо”,Боди суварга



Усан луу жилийн хаврын дунд харагчин туулай сарын шинийн 3 ны Дашнямтай билэгт сайн өдөр Эрдэнэцогт сумын Пандэ-Чойнхорлон хийдийн лам нараар адислуулан аравнайлж жанлавлалаа.




## Нуурын үзүүр дэх бурхантай хад

Уугуул нутгийн үрсүүд нь суугуул нутгийн хойморгтоо

Бурхан бүтээж залаад буян үйлдэж залбирсан...


/МУСТАжилтан Цагааны Чулуунхүүгийн ерөөлөөс/



/Уугуул нутгийн унаган хүү удамт хүний үр сад унаган нутаг уул усандаа учиртай шүтээн бурханыг сүсэглэн бүтээсэн билээ. 2001 онд Жаргалант сумын унаган хүү Жанцангийн Оюунхүү бүтээсэн билээ/

## ЖАРГАЛАНТ СУМ ДАХЬ ХАДНЫ СҮГ ЗУРАГ БҮХИЙ ГАЗРУУД

Баянхонгор аймгийн Жаргалант сумын төвөөс 32 километрт оршдог *Хөшгийн өврийн Улаан хаданд эртний сүг зураг* олон бий.





## БУГАТЫН ХАДНЫ СҮГ ЗУРАГ

Бугатын хадны сүг зураг нь нилээд том/5 ханатай гэрийн дайтай/ том боржин чулуун дээр байх ба энэ хадны сүг зургаар нь тухайн газрыг “Бугат” хэмээн нэршсэн.



Жаргалант сумын төвөөс 65 километрт Өлзийт-Өндөрийн 2-р багийн нутаг болох Хатавчийн хаданд сүг зураг байдаг.



## Цохиотын уулзварын буган хөшөө чулуу

Баянхонгор аймгийн Жаргалант сумын төвөөс зүүн хойш 38 км-т хөндлөн булагийн 3-р багийн нутагт Цохиотын уулзвар хэмээх газар нэгэн хөшөө чулуу бий.



Цохиотын уулзварын  
буган хөшөө чулуу

Энэ хөшөөний өндөр 2 м орчим, өргөн нь 40 см орчим, зузаан нь 25 см орчим хэмжээтэй бөгөөд дөрвөн тал орчим *боржин чулуу* юм.

### Сүүжийн булагийн буган хөшөө чулуу

Баянхонгор аймгийн Жаргалант сумын төвөөс зүүн зүгт 18-км-т Цагаан дөрөлж гэдэг газарт байрлах буган хөшөө чулуунууд



Сүүжийн булагийн буган хөшөө чулуу



## **Улаан хурууны буган хөшөө чулуунууд**

Баянхонгор аймгийн Жаргалант сумын төвөөс зүүн урд зүгт 15 км-т орших Улаан хуруу хэмээх газар байдаг.



Улаан хуруунд 8 хөшөө чулуу хол хол орших бөгөөд саарал боржин хөшөө чулуунууд юм.



## Мандалын амны буган хөшөө чулуунууд

Энэ нь Хөндлөн булагийн 3-р багийн нутаг юм. Эдгээр хөшөө чулуунууд нь нь хоорондоо 1м орчим зайтайгаар нэлээд ойр ойрхон орших ба өндөр нь 50 см-1м орчим байдаг.




## Хөшөөгийн булангийн хөшөө чулуу

Баянхонгор аймгийн Жаргалант сумын төвөөс зүүн хойд зүгт Хөшөөгийн буланд ганц хөшөө чулуу бий. *Хөшөө чулуу нь 1,20 орчим см ба зүүн тийш хазайж тогтсон* чулуу юм.



## Байгалийн цогцолборт газрууд



### Жаргалант сумын нутаг дахь нуур,булаг,харз, гол ус бүхий газрууд Биндэрьяа Хөх-Нуурын домог

Баянхонгор аймгийн Жаргалант сумын нутаг Өлзийт-Өндөрийн 2-р багийн нутагт Биндэрьяа Хөх-Нуур гэж бий.

Дээр үед нуурын зах дээр ганц үнээтэй нэг ядуу айл байж. Тэгтэл нэг өдөр ганц үнээгий нь *нуураас нэг бух гарч ирж ганц үнээг дагаж тэр ядуу айл олон үнээтэй болсон гэдэг.*

### Давст цагаан нуур

Талын хонхорт цайрсан байн цагаан Давст нуур  
Таван толгойн чимэг болсон Чойндон Яйшил хайрхан  
/”Байдраг нутгаа магтаалаас.../

Давст цагаан нуур нь Баянхонгор аймгийн Жаргалант сумын төвөөс 45 км-т урд зүгт оршдог ба Давст нуураас жилд 100-200 тонн давсыг олборлох бололцоотой.





## Устын рашаан

Баянхонгор аймгийн Жаргалант сумын төвөөс зүүн зүгт 35 км-т Нугалгааны голд байдаг. **Устын рашаан нь** ходоод дотрын өвчинд уудаг хүйтэн рашаан юм.



## Биндэръяа Хөх нуурын рашаан

*Биндэръяа Хөх нуурын рашаан нь* Баянхонгор аймгийн Жаргалант сумын төвөөс хойш 70 км зайд далайн мандлаас 2000 м Рашаан нь их гүнийх бөгөөд хөрсний устай холилдоогүй гарах тул 15 градусын халуун ходоод доторын рашаан юм.



## Өлийн амны амьд харз

**Өлийн амны амьд харз нь** Баянхонгор аймгийн Жаргалант сумын 1-р багийн нутаг Өлд байх ба ундарга сайтай хөрсний устай холилдоогүй газрын гүнээс оргилон гардаг.



Энэхүү харз сумын төвөөс 18 орчим км-т байдаг ба 2007 онд Өлийн амьд харзыг хашиж хамгаалсан. Өвлийн тэсгэм хүйтэнд хөлддөггүй рашаан төст харз билээ.

## Ханхарын харз


Ханхарын амны амьд харз нь Баянхонгор аймгийн Жаргалант сумын 1-р багийн нутагт орших ба ундарга сайтай хөрсний устай холилдоогүй газрын гүнээс оргилон гардаг. Өвлийн хүйтэн /1-р сард/ очиход хүртэл шумуултай байдаг.



Ханхарын амьд харзнаас сумын төвийнхөн өвөл ганзагалаж ирж уух бөгөөд ходоод доторт сайн гэлцдэг. Ханхарын харзыг оготнотой булаг гэдэг.

## Цохиотын халуун рашаан

Цохиотын халуун рашаан нь Баянхонгор аймгийн Жаргалант сумын төвөөс зүүн хойш 32 км зайд далайн мандлаас 2000 м-т өргөгдсөн газар оршино.



Цохиотын халуун рашаан нь Хангайн уулархаг газрын умард хэсэгт орших халуун рашаануудтай физик, химийн найрлагаараа төстэй ч өвөрмөц онцлогтой ходоодны хүхэрлэг рашаан юм.

## Ялаат булаг

Жаргалант сумын Өлзийт-Өндөрийн 2-р багийн нутаг Ялаатад “Ялаат булаг” гэж байдаг. Ялаат булагийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2006 оны 26 дугаар тогтоолоор сумын хамгаалалтанд авсан. Өлзийт-Өндөр хайрханыг зуны эхэн сард тахиж,наадмыг Ялаат булагт хийдэг байсан гэж манай долоогийнхон ярьдаг ба энэхүү булагаа шүтэн дээдэлж ирсэн.





## **БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН НУТАГ ДАХЬ БҮЛШ,ХИРГИСҮҮРҮҮД**

### **Дөтийн амны хиргисүүрүүд**

Дөтийн аманд ойрхон 4 хиргисүүр байх ба бидний өвөг дээдсийн ярьж байснаар тойруулгатай хиргисүүр бол нилээд том улсын шарил гэлцдэг байсан.



### **Хэргэстийн амны хиргисүүрүүд**

Баянхонгор аймгийн Жаргалант сумын баруун хойд зүгт нарийн урт хөндий орших бөгөөд түүнийг Хиргэстийн ам гэдэг.



Хэргистийн хойд, урд салаанд том жижиг нийлсэн 50 гаруй эртний булш,хиргисүүрүүд олон байдгаас “Хэргэстий” хэмээн нэршсэн.

## Цагаан дөрөлжний хиргисүүрүүд

Баянхонгор аймгийн Жаргалант сумын төвөөс зүүн зүгт 15 км-т Цогт хайрханы зүүн хөндийд Цагаан дөрөлжний гол, Хүрмийн голын хооронд ойр ойрхон байрласан эртний том, жижиг булш хиргисүүрүүд олон байх ба алсаас сүрлэг тод том харагддаг.



Цагаан дөрөлжний хиргисүүрүүд

## ЖАРГАЛАНТ СУМЫН НУТАГ ДАХЬ ХҮРЭЭНИЙ БУУРЬ ТУУРЬ БҮХИЙ ГАЗРУУД

### Байдрагийн хүрээ

Байдрагийн хүрээ нь 1820 –иод оны үед Нарт хонгорын өвөрт Чоймцон гарав уулын ард Намжил хайрханы баруун талд Цагаан хайрхан уулын зүүн тал энэ 4 уулын дунд Байдраг Мандал 2 голын уулзварт байжээ.



Байдрагийн хүрээ/архивын зураг/



Байдрагийн хүрээний  
буурин дээр босгосон  
суварга

1990 –ээд оноос орон нутагт Байдрагийн хийдээ сэргээх буянт үйлс өрнөж долоон наснаасаа хийдэд шавилан сууж байсан Сүүл лам санаачлан /тэрбээр хүрээний үе үеийн эрдэм номтой хувилгаадын захиасын дагуу Байдрагийн хүрээ хуучин хийд байсан газар дээр суварга босгосон./лам Самбуу агаагийн ярианаас/

## Эрдэнэ вангийн хийд

Эрдэнэ вангийн хийд нь Жаргалант сумын төвд оршдог. Энэхүү хийдийг 1990 -ээд оноос орон нутагт буяны үйлс дэлгэрч хийдээ сэргээх ажлууд нилээд өрнөж байх үед нутгийн лам Сүүл гуайн санаачилсанаар тэр үеийн удирдлагуудын дэмжлэгтэйгээр “Эрдэнэ ван”-гийн хийдийг барьж босгосон



## Нуурын дугана


Манай хошуунд Биндэръяа Хөх нуурын зүүн урд Уулангийн булан гэдэг газар 17 том, жижиг дуганатай олон арван шавь нар чуулсан Чогчин дуган гэж байсан. Энэ дуганын туурь одоо Дуганы хонхор хэмээн нэршин нутгийн сүсэгтэн олон эх болсон зургаан зүйл хамаг амьтны тусын тулд сүү цагаан идээний дээжээ өргөн шүтэн биширдэг.



## ЖАРГАЛАНТ СУМЫН НУТАГ ДАХ ТҮҮХИЙН ДОМОГТ ХАЙРХАН ОВОО,ДАВАА

### Сүмбэнцацал хайрханы домог

Баянхонгор аймгийн Жаргалант сумын Сүмбэнцацал хайрхан уул нь сумын төвийн зүүн зүгт орших ба дээр үед тахидаг байсан эм савдагтай тахилгатай уул юм.



### Мандал хайрхан


Байдрагийн Мандал хайрхан Мөрөнгийн бууцны наад голд нэг тасархай толгой байдаг.



Дээр үед түүнийг тахьдаг байсан гэж хөгшчүүл ярьдаг байсан .Толгойн араас гардаг замтай урд бэлд нь бөх барилддаг талбайтай тийм толгой байдаг түүнийг Мандал хайрхан гэж нэрлэдэг. Дээр үед ган, зуд болохоор энэ хайрханыг тахьдаг байжээ.

## Чойндон-Яйшил хайрхан

Баянхонгор аймгийн Жаргалант сумын төвөөс 50 километр Чойндон-Яйшил хайрхан нь Давсан талын нутагт оршдог.




Энэхүү хайрханыг *намрын эхэн сард зөв эргүүлэгтэй цагаан дун дуугаргаж даага уралдуулж тахьдаг байсан* ба хамгийн сүүлчийн даагыг баян ходоод хэмээн цоллож унасан хүүхдэд хонины болсон ходоод өгдөг байсан. Хонины шүүс, цагаан идээгээр тахьдаг байсан байна.



## Өлзийт-Өндөр хайрхан

Өлзийт-Өндөр хайрхан нь сумын төвөөс 35 км-т байх ба 2-р багийн төв нь хайрханы өвөрт оршдог.



Өлзийт-Өндөр хайрханыг *зуны эхэн сар гаруут даага, азарга уралдуулж шигшээ наадмыг Ялаат булагт* хийдэг байжээ. Энэхүү хайрханыг тахихдаа боов, хайлмаг зэрэг цагаан идээгээр тахьдаг байсан байна.

## Чоймцон-Гарав уул

Баянхонгор аймгийн Жаргалант сумын Хөндлөн булагийн 3-р багийн нутагт орших Чоймцон-Гарав уул нь дээр үед хүрээ байсны урд талд орших уул юм.

## Цагаан хайрхан

Баянхонгор аймгийн Жаргалант сумын Хөндлөн булагийн 3-р багийн нутагт орших Цагаан хайрхан нь сумын төвөөс 35 км-т орших ба энэхүү Цагаан хайрханы дээр нь *“Бунхан” нэртэй том цагаан чулуу байдаг.*

## Хүнцэлт

Баянхонгор аймгийн Жаргалант сумын Хөндлөн булагийн 3-р багийн нутагт орших “Хүнцэлт” нэртэй газар нь сумын төвөөс 70-аад км-т оршдог. Дээр үед энд эм барьдаг хүн байжээ. Хүний биений арьсан дээр яр шарх гарсан үед “Хүнцэл” тавьж өгөөд *наалдвал газар лусын өвчин, наалдахгүй бол газар лусын холбогдолгүй гэж эмчилдэг* байсан байна.

## Намжил хайрхан

Үе дамжин шүтэгдсэн-Мандал хайрханы тахилга

Хүн зоны буяныг түшсэн-Намжил хайрхан ээжий

/Ч.Далантайн “Байдраг нутгаа магтъя”шүлгээс.../

Баянхонгор аймгийн Жаргалант сумын Хөндлөн булагийн 3-р багийн нутагт орших “Намжил хайрхан” уул нь сумын төвөөс 50 км-т байдаг.

“Намжил хүртэн” гэж эм барьдаг сайн хүн байсан ба энэхүү уулыг тэр хүртэн *хонины чанасан ууц, шүүс бэлтгэж тахьдаг* байсан нь хожмоо тэр хүний нэрээр нэрлэн



тахьдаг тахилгатай уул болгосон. Намжил хайрхан уулыг хонины чанасан ууц, шүүс бэлтгэж бөх тэх хүнээр овоон дээр өргүүлж аваачдаг байсан ба морь уралдуулдаггүй байжээ

## **Лам Б.Санжаасүрэнгийн бүтээсэн “Бурханы Боди суварга**

Энэхүү суварганд нутгийн ариун дагшин газрын шороо,чулуу,арц,ус мод тэргүүтэн болон Цагаан лянхуа судар, Гаанжуурын 108 ботийг хийж төрийн тахилгат Богд уулнаас амин/сорогчин/ модыг 108 зай Бурхан багшийг шашны тэг,журмын дагуу Урлахуйн Ухааны төвөөс бүтээлгэн залсан.



## **Хагийн дөрөлжний овоо**

Жаргалант Галуут сумын хилийн зааг Галуут,Баянхонгор явах замд байдаг Нам толгойн 1-р багийн нутагт орших Хагийн дөрөлжний овоон дээр 2 м өндөр гантиг чулуун дээр урд талд нь “Жаргалант”,хойд талд нь “Усан луу”,зүүн хажуу талд нь “70 жил” гэж байгаль хамгаалагч Гүррагчаагийн Батэрдэнэ маш чадварлагаар урлан сийлсэн байдаг.



Хагийн дөрөлжний Жаргалант,Галуут сумдын хилийн цэсийн баганат хөшөө, овоо

## Цаазын хад

Улиастай хотыг байгуулах үед Манжийн цэрэг дайран өнгөрдөг Манж амбаны дамжин өнгөрүүлэх бааз манай суманд байсан гэдэг.

Баянхонгор аймгийн Жаргалант сумын төвөөс зүүн хойно “Цаазын хад” хэмээх хад байдаг. Дээр үед энд гэмт хэрэг хийсэн хүмүүсийн ялыг уншин цаазалдаг байсан “Цаазын хад”-тай байжээ.



## Зарлигийн цохио

Баянхонгор аймгийн Жаргалант сумын төвөөс зүүн хойно Мандалын Чулуутын аманд Зарлигийн цохио гэж хад бий.



Энд дээр үед хэрэгтнүүдийн зарлигийг уншин доохно талд нь Цаазын хаданд авчиран хороодог байсан гэж нутгийн хөгшчүүл ярьдаг.

## Хатавчийн гэр асга

Баянхонгор аймгийн Жаргалант сумын нутаг Өлзийт-Өндөрийн 2-р багийн нутаг Хатавчийн эхэнд “Тэр асга” гэж том агуй байдаг ба одоо түүнийг хэн ч олдоггүй түүхтэй.

## Байдрагийн Бугат

Баянхонгор аймгийн Жаргалант сумын Хөндлөн булагийн 3-р багийн нутагт орших Байдрагийн Бугат нь сумын төвөөс 60 км-т оршдог. Эрт дээр үеийн сайн эрүүд хулгай хийсэн малаа нуудаг байсан өвөр тогтоцтой газар энд “суурь үхэр” багтдаг гэлцдэг.

## Номхон даваа

Дээр үед Цохиотын Сөдөтийн Номхон давааг “Улаан даваа” гэж нэрлэдэг байсан. Улаан даваагаар өдөрт нэг хүн 3 давдаггүй, давбал үхдэг байжээ. Тэгээд энэ давааг нутгийн нэгэн том лам номхруулж “Улаан” нэрийг “Номхон” болгосон гэдэг. Бидний өвөг дээдэс энэ хайрханаа үеийн үед шүтэн дээдэлж ирсэн билээ.

## Хар-Анаг

Хадтай, модтой, алттай-

“ХарАнагийн хавцал”

Дотроо эрдэнэсээ эрхэмлэсэн-

“Догшин” бас “Дархан” савдаг


Баянхонгор аймгийн Жаргалант сумын Хөндлөн булагийн 3-р багийн нутагт орших Хар-Анаг нь байгалийн үзэсгэлэнтэй сайхан газар ба сумын тусгай хамгаалалтанд 2007 оны 4-р сарын 2 ны өдрийн 05 тоот тогтоолоор авсан.





## Монгол улсын начин Б.Бордухын өргөж тавьсан чулуу

Баянхонгор аймгийн Жаргалант сумын нутаг Өлзийт-Өндөрийн 2-р багийн нутаг Биндэрьяа Хөх-Нуурын хөвөөн дээр Монгол улсын начин, хүндийн өргөлтийн дэлхийн аваргын хүрэл медальт Б.Бордухын өргөж тавьсан чулуу байдаг.



Энэхүү чулуу нь 150 орчим кг жинтэй ба начин маань 52 настайдаа 1982 онд өргөж тавьж байсан нь сумынхаа нэрийг улсад дансалсан нутгийн хүүгийн эр бярыг аргагүй харуулах бөлгөө.

### Ганц мод буюу Алтан босго


Баянхонгор аймгийн Жаргалант сумын Хөндлөн булагийн 3-р багийн нутагт орших Ганц мод буюу Алтан босго нь сумын төвөөс 36 километрт оршдог ба 2007 оны 4-р сарын 2 ны өдрийн 05 тоот тогтоолоор сумын тусгай хамгаалалтад авсан **удган мод** юм.



“Ганц мод буюу Алтан босго”-ыг ногоон торгон дээлтэй, зандан хувин барьсан охин савдагтай гэдэг.

## Төрийн соёрхолт Соёлын Гавъяат зүтгэлтэн Цэндийн Намсрайн төрсөн газар

Жаргалант сумын Хөндлөн булагийн 3-р багийн нутаг болох Бумбатын буурал бууцанд Төрийн соёрхолт Соёлын Гавъяат зүтгэлтэн Цэндийн Намсрай гуай төрсөн билээ. 2004 онд Ардын жүжигчин Цогзолмаа гуай үр хүүхдүүдийнхээ хамтаар энэхүү хөшөөг босгож байсан.



Домог-2011 Газрын даамал Д.Пагмасүрэн

22

## Бөх мод

Бөх мод нь Баянхонгор аймгийн Жаргалант сумын төвөөс зүүн хойш Хөндлөн булагийн 3-р багийн нутагт орших ба Ардын хувьсгалаас өмнө хошууны бөхчүүд очиж хүндэтгэл үзүүлэн мөргөж тахьдаг байжээ.

